



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цэнхэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 52
танай _____-ны № _____-т

ЦЭНХЭР СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.ХОРОЛСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,001,846.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 936,024.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 үндсэн зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	295,111,243.74	142,835,736.41
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	221,570,875.10	51,748,367.77
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	221,570,875.10	51,748,367.77
3121	Төгрөг	221,570,875.10	51,748,367.77
31211	Төрийн сангийн харилцах	221,570,875.10	51,748,367.77
33	АВЛАГА	-	-
335	Бусад авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	73,540,368.64	91,087,368.64
351	Түүхий эд материал	59,503,533.64	68,375,033.64
35110	Тусгай зориулалттай материал	56,640,033.64	65,511,533.64
35130	Эм боох материал	2,863,500.00	2,863,500.00
354	Хангамжийн материал	14,036,835.00	22,712,335.00
35410	Бичиг хэргийн материал	1,295,220.00	6,527,720.00
35420	Аж ахуйн материал	10,325,115.00	10,028,115.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,000,000.00
35450	Барилгын засварын материал	2,416,500.00	5,156,500.00
346	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	256,538,475.82	308,078,774.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	256,538,475.82	308,078,774.71
392	Биет хөрөнгө	225,546,475.82	277,119,274.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	233,646,634.00	233,646,634.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,325,851.10)	(52,413,770.98)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	62,207,890.00	42,469,680.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,873,568.94)	(14,027,326.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,196,147.00	70,290,790.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,831,201.87)	(4,428,158.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,736,180.00	5,736,180.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,628,680.01)	(5,628,680.01)
39217	Ном	1,418,926.74	1,473,926.74
393	Биет бус хөрөнгө	30,992,000.00	30,959,499.98
39301	Програм хангамж	650,000.00	650,000.00
39302	Хасагдуулга	-	(32,500.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,342,000.00	30,342,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	551,649,719.56	450,914,511.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,706,590.80	997,821.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,706,590.80	997,821.10
413	Өглөг	1,706,590.80	997,821.10
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	997,821.10
413102	НДШ-ийн өглөг	-	997,821.10
41320	Бараа, үйлчилгээний зардлын өглөг	1,706,590.80	-
413202	Түлш халаалтын өглөг	1,706,590.80	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	549,943,128.76	449,916,690.02
51	Засгийн газрын хувь оролцоо	549,943,128.76	449,916,690.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	168,990,231.95	168,990,231.95
51101	Өмч: - төрийн	168,990,231.95	168,990,231.95
512	Хуримтлагдсан үр дүн	378,354,651.81	269,683,213.07
51210	Өмнөх үеийн үр дүн	378,354,651.81	378,354,651.81
51220	Тайлант үеийн үр дүн	-	(100,026,438.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,598,245.00	2,598,245.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	551,649,719.56	450,914,511.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	866,781,980.00	868,802,090.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,454,880.00	63,518,490.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,454,880.00	63,518,490.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө	17,404,880.00	50,972,890.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	2,050,000.00	12,475,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	847,327,100.00	805,283,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	812,521,200.00	723,157,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	812,521,200.00	723,157,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,805,900.00	82,126,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,805,900.00	82,126,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	741,924,532.63	968,828,528.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	741,924,532.63	968,828,528.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	741,603,995.63	921,042,865.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,485,334.54	705,543,548.51
210101	Цалин	378,003,212.16	422,082,399.73
210102	Нэмэгдэл цалин	140,395,005.13	243,858,902.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,725,000.00
210104	Урамшуулал	22,087,117.25	34,877,246.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,066,597.73	88,570,473.92
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	45,739,685.58	60,466,867.47
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,451,944.37	7,025,887.80
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,999,175.07	3,512,947.65
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,565,359.33	3,512,947.65
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	10,310,433.38	14,051,823.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,191,953.80	35,267,946.40
210301	Гэрэл цахилгааны зардал	3,513,263.00	4,201,796.00
210302	Түлш, халаалтын зардал	25,978,690.80	28,644,150.40
210303	Цэвэр, бохир усны зардал	1,700,000.00	2,422,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	200,000.00	1,593,700.00
210408	Бараа материал акталсны зардал	200,000.00	1,593,700.00
2105	Нормативт зардал	65,314,298.00	54,717,605.00
210502	Хоол, хүнс	65,314,298.00	54,717,605.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,559,500.00	1,960,000.00
210604	Урсгал засвар	3,559,500.00	1,960,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,251,000.00	2,134,323.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,251,000.00	2,134,323.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,535,311.56	31,255,269.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,296,070.00	16,076,378.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	7,802,700.00	5,815,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,436,541.56	9,363,091.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	320,537.00	47,785,662.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,633,600.00

Архангай аймгийн Цэнхэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,633,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	320,537.00	39,152,062.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	320,537.00	39,152,062.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	124,857,447.37	(100,026,438.74)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЫН ДҮН 4	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	124,857,447.37	(100,026,438.74)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	847,327,100.00	805,353,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	847,327,100.00	805,283,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	812,521,200.00	723,157,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	812,521,200.00	723,157,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,805,900.00	82,126,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,805,900.00	82,126,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	743,118,430.27	965,245,607.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	743,118,430.27	965,245,607.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,797,893.27	917,459,944.53
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	540,136,434.54	705,543,548.51
210101	Үндсэн цалин	378,003,212.16	422,082,399.73
210102	Нэмэгдэл	140,395,005.13	243,858,902.03
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	4,725,000.00
210104	Урамшуулал	21,738,217.25	34,877,246.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,066,597.73	87,572,652.82
210201	Тэтгэврийн даатгал	45,739,685.58	59,469,046.37
210202	Тэтгэмжийн даатгал	5,451,944.37	7,025,887.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,999,175.07	3,512,947.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,565,359.33	3,512,947.65
210205	Эрүүл мэндийн даатгал	10,310,433.38	14,051,823.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,485,363.00	37,974,537.20
210301	Гэрэл, цахилгаан	3,513,263.00	4,201,796.00
210302	Түлш, халаалт	24,272,100.00	31,350,741.20
210303	Цэвэр, бохир ус	1,700,000.00	2,422,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-

Архангай аймгийн Цэнхэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	65,314,298.00	54,720,825.00
210502	Хоол, хүнс	65,314,298.00	54,720,825.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,458,900.00	3,816,323.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,458,900.00	3,816,323.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,336,300.00	22,832,058.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,533,600.00	16,647,058.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,802,700.00	6,185,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	320,537.00	47,785,662.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,633,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,633,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	320,537.00	39,152,062.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв	320,537.00	39,152,062.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	104,208,669.73	(159,892,007.33)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,058,900.00	9,930,500.00
	Дотоод эх үүсвэрээр	4,058,900.00	9,930,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,058,900.00	9,930,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,058,900.00)	(9,930,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	100,149,769.73	(169,822,507.33)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	121,421,105.37	221,570,875.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	221,570,875.10	51,748,367.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	168,990,231.95	2,598,245.00	253,497,204.44	425,085,681.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,990,231.95	2,598,245.00	253,497,204.44	425,085,681.39
Тайлант үеийн үр дүн	-	-	124,857,447.37	124,857,447.37
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	168,990,231.95	2,598,245.00	378,354,651.81	549,943,128.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,990,231.95	2,598,245.00	378,354,651.81	549,943,128.76
Тайлант үеийн үр дүн	-	-	(100,026,438.74)	(100,026,438.74)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	168,990,231.95	11,243,245.00	269,683,213.07	449,916,690.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,001,846,500.00	936,024,044.53	65,822,455.47	93.43
УРСГАЛ ЗАРДАЛ		1,001,846,500.00	936,024,044.53	65,822,455.47	93.43
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		993,212,900.00	927,390,444.53	65,822,455.47	93.37
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		717,065,200.00	705,543,548.51	11,521,651.49	98.39
Үндсэн цалин	210101	436,605,300.00	422,082,399.73	14,522,900.27	96.67
Нэмэгдэл	210102	253,833,900.00	243,858,902.03	9,974,997.97	96.07
Унаа хоолны Хөнгөлөлт	210103	-	4,725,000.00	(4,725,000.00)	-
Урамшуулал	210104	26,626,000.00	34,877,246.75	(8,251,246.75)	130.99
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		88,869,600.00	87,572,652.82	1,296,947.18	98.54
Тэтгэврийн даатгал	210201	60,285,500.00	59,469,046.37	816,453.63	98.65
Тэтгэмжийн даатгал	210202	7,146,000.00	7,025,887.80	120,112.20	98.32
ҮОМШӨ-ний даатгал	210203	3,573,000.00	3,512,947.65	60,052.35	98.32
Ажилгүйдлийн даатгал	210204	3,573,000.00	3,512,947.65	60,052.35	98.32
Эрүүл мэндийн даатгал	210205	14,292,100.00	14,051,823.35	240,276.65	98.32
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		77,126,600.00	37,974,537.20	39,152,062.80	49.24
Гэрэл, цахилгаан	210301	15,076,200.00	4,201,796.00	10,874,404.00	27.87
Түлш, халаалт	210302	59,600,000.00	31,350,741.20	28,249,258.80	52.60
Цэвэр, бохир ус	210303	2,450,400.00	2,422,000.00	28,400.00	98.84
Хангамж, бараа материалын зардал		-	-	-	-
Нормативт зардал		68,034,600.00	54,720,825.00	13,313,775.00	80.43
Хоол, хүнс	210502	68,034,600.00	54,720,825.00	13,313,775.00	80.43
Эд хогшил, урсгал засварын зардал		5,000,000.00	5,000,000.00	-	100.00
Урсгал засвар	210604	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
Томилолт, зочны зардал		-	-	-	-

Архангай аймгийн Цэнхэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,854,200.00	3,816,323.00	37,877.00	99.02
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210806	3,854,200.00	3,816,323.00	37,877.00	99.02
Бараа үйлчилгээний бусад зардал		33,262,700.00	32,762,558.00	500,142.00	98.50
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	26,667,900.00	26,577,558.00	90,342.00	99.66
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	210902	6,594,800.00	6,185,000.00	409,800.00	93.79
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,633,600.00	8,633,600.00	-	100.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг		8,633,600.00	8,633,600.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213209	8,633,600.00	8,633,600.00	-	100.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	-	-	-
Дотоод эх үүсвэрээр					
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,001,846,500.00	766,201,537.20	235,644,962.80	76.48
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		919,649,900.00	723,157,000.00	196,492,900.00	78.63
Улсын төсвөөс санхүүжих	131001	727,293,700.00	723,157,000.00	4,136,700.00	99.43
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	131009	192,356,200.00	-	192,356,200.00	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		82,126,600.00	42,974,537.20	39,152,062.80	52.33
Орон нутгийн төсвөөс	132001	82,126,600.00	42,974,537.20	39,152,062.80	52.33
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		70,000.00	70,000.00	-	100.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200042	70,000.00	70,000.00	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		221,570,875.10	221,570,875.10	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		221,570,875.10	51,748,367.77	169,822,507.33	23.36
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
БАЙГУУЛЛАГЫН ТОО		1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО		27.50	26.50	1.00	96.36
Удирдах ажилтан		1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан		8.50	8.50	-	100.00
Үйлчлэх ажилтан		18.00	17.00	1.00	94.44
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		145.00	145.00	-	100.00
Төрийн өмчит СӨБ байгууллага		145.00	145.00	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 13,730.1 мянган төгрөгийн 1 алдаа илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

- 2025.06.30-наар Үндсэн хөрөнгийн тайлангийн үлдэгдэл, орлого, зарлагыг харгалзах ерөнхий дэвтрийн дүнгийн үлдэгдэл, дебет, кредиттэй тулгахад 13,730.1 мянган төгрөгийн зөрүү гарсан. Үндсэн хөрөнгийн өртөг 75.0 мянган төгрөгөөр, хуримтлагдсан элэгдэл 13,805.1 мянган төгрөгөөр тус тус ерөнхий дэвтрийн данс дахь дүн дутуу илэрхийлэгджээ. Өртөг 75.0 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 4,348.1 мянган төгрөг нь өмнөх тайлант үеүдэд үүссэн бол тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн элэгдлийг 9,457.0 мянган төгрөгийн элэгдэл дутуу байгуулжээ.

Аудитаар залруулаагүй 4,794.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 1,552.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 3,241.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 4,794.2 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 11,332.8 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Ээлжийн ажил эрхэлдэг нэр бүхий 2 ажилтанд "Нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс" 1,108.5 мянган төгрөг олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн хуулийн 109 дүгээр зүйлийн 109.9 "Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. 2024 оны 8 сард дутуу олгосон 2 хоногийн цалинг нэр бүхий 12 ажилтанд нөхөн олгоходоо 444.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцон олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. "Балансын урамшуулал олгох тухай" Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.09.03-ны өдрийн Б/28 дугаар тушаалуудаар "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 623.6 мянган төгрөгийн, няравт 552.5 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 1,176.1 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

51.1.Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 863.6 мянган төгрөг суутган 7,770.2 мянган төгрөгийг 24 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 2,065.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Үүнээс	
					Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн алдаатай тайлагнал	1	13,730.1	1	13,730.1	1	13,730.1
Нийт дүн	1	13,730.1	1	13,730.1	1	13,730.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү тооцож олгосон	2	1,552.7	2	1,552.7				
НДШ дутуу төлсөн	1	2,065.3			1	2,065.3		
Балансын урамшуулал олгосон	1	1,176.1			1	1,176.1		
Дүн	4	4,794.2	2	1,552.7	2	3,241.4		